Авлага	3614926.8	1503478.2	2111448.6
Бараа материал	511376.3	731531.6	220155.3
Үндсэн хөрөнгө	32333159.8	31454029.9	879130.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>36459463.1</b>	<b>33755216.5</b>	<b>2704247.0</b>
Өр төлбөр	724077.2	-	724077.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	35735385.9	33755216.5	1980169.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>36459463.1</b>	<b>33755216.5</b>	<b>2704247.0</b>

Дээрх хүснэгтээс харахад Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2704.2 сая төгрөгөөр буурсанд материаллаг нөлөө үзүүлж байгаа данс нь мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Байгууллагын төрийн сан дансанд оны эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 66.2 сая төгрөг байршиж байна.
- ✓ Авлага дансны оны эцсийн үлдэгдэл 1.5 тэрбум нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах төлбөрт үйлчилгээний авлага бөгөөд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй тооцоо нийлж актаар баталгаажуулсан байна.

- ✓ Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 220.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 997.5 сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авч оны эцэст эм эмнэлгийн хэрэгслийн эцсийн үлдэгдэл 267.5 сая төгрөг болсонтой холбоотой байна.
- ✓ Үндсэн хөрөнгө данс 879.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд өөрийн хөрөнгөөр 908.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, дээд шатны байгууллага болон олон улсын байгууллагаас хандив тусламжаар 1016.6 сая төгрөгийн хөрөнгө нийт 1924.7 сая төгрөгийн хөрөнгө бүртгэж, холбогдох байгууллагын тушаал шийдвэрээр 3097.0 сая төгрөгийн хөрөнгө акталж устгасантай холбоотой байна.
- ✓ Өмнөх онд ЭМД-аас авах авлагатай холбоотой үүссэн бусдад өгөх 724.1 сая төгрөгийн өр төлбөрийг тайланд онд барагдуулж дууссан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг бараа материалын үнийн өсөлт, хэвтэн эмчлүүлэгчдийн тоо нэмэгдэж ачаалал ихэссэн, ажилчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой, мөн тасаг нэгжүүдэд урсгал засвар хийгдэх шаардлагын улмаас санхүүжүүлэх эх үүсвэрийг нэмэгдүүлж эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 18,337.3 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 281.3 сая төгрөг нийт 18,337.3 сая төгрөгийг нэмэгдүүлэн тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлангийн хугацаанд тухайн байгууллага нь үндсэн үйл ажиллагааны орлогоос 723.0 сая төгрөгийн орлого олж, эрүүл мэндийн даатгалын сангаас 19,544.3 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр нийт 20,201.2 сая төгрөгийн зардал санхүүжүүлж, 66.1 сая төгрөг төрийн сангийн дансанд үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн сайдын 2022.03.14 өдрийн 1а/1169 тоот албан бичгийн 2.4-д эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авч буй төсөвт байгууллагуудын нэмэлт дансыг 2022 оны 03 дугаар сарын 15-аас хойш ашиглахыг хориглож, нэмэлт санхүүжилтийн дансанд байгаа үлдэгдлийг үндсэн дансанд шилжүүлж эх үүсвэрийг тухайн байгууллагын урсгал зардлын хөтөлбөрийн адил төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоор 120010 гэх ангиллаар төсвийн төлөвлөлтийн программд шивж оруулах чиглэл ирүүлснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Д.Балжинням 2022 оны 01 дүгээр сарын 29-ноос 02 дугаар сарын 13-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар, аудитын менежер А.Цэцэгсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 14/06 албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 18,482.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 369.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 295.7 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын гүйцэтгэлийн шатанд материаллаг байдал төлөвлөлтийн шатнаас шинэчлэн тогтоогдож байгаа шалтгаан нь эрүүл мэндийн салбар гүйцэтгэлээр санхүүжиж байгаатай холбоотой зардлын данс нэмэгдсэнтэй холбоотой шинэчлэн тогтоолоо.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 21,921.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 438.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 350.7 сая төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2 - 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 172 мэдээллээс хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 170 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тухайн байгууллагад гэрээний үүргийг бүрэн хангаагүй, бэлтгэн нийлүүлэгч компаниудын гэрээний үүргийн биелэлтийг дүгнээгүй, цалингийн зардлыг гүйлгэн зарцуулсан, зардал зориулалт бусаар зарцуулсан, бусдад өгөх өр төлбөрийг барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчлүүдэд албан шаардлага, зөвлөмж өгөгдсөнийг тайлант онд бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0,0	0,0	0,0	100
Албан шаардлага	2	126500.0	2	126500.0	100
Зөвлөмж	2	120200.0	2	120200.0	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>246700.0</b>	<b>4</b>	<b>246700.0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудалд Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 49/А 118 дугаар тушаалын “Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээнээс олсон орлогын бүртгэл, зарцуулах журмын 2.1. Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлого, зарцуулалтыг бодитой төлөвлөж, жил бүрийн төсөвтөө тусгаж Эрүүл мэндийн тухай хууль болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасан Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж, гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллах хууль, журмын хэрэгжилтийг ханган ажилсан эсэхийг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 284.9 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс 10.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчилд дахин давтан гаргахгүй байх 31.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, 242.8 сая төгрөгийн 3 зөвлөмж өглөө

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

## 5.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй

## 5.2 Төлбөрийн акт

- Ач ангаах ухааны Их сургуультай хамтран магистрын сургалт зохион байгуулах гэрээ хийж багш нарын томилолт, унааны зардалд 10.3 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн, байгууллагын дотоод журмын 2.7.8-д "аспирантур, магистр, доктор зэрэг эрдмийн зэрэг цол хамгаалах сургалтын зардлыг байгууллага хариуцахгүй" гэсэн заалтуудтай тус тус нийцээхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Анхан шатны баримтаас тулган хянахад байгууллагын үйл ажиллагааны бус зардалд зарцуулсан 0.5 сая төгрөгийг зөрчил илэрсэн Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

## 5.3 Албан шаардлага

5.3.1 БОЭТ-ийн захирлын тушаалаар хоолны зардлаас сургалтын хоол, ажилчдын зугаалга, олон нийтийн арга хэмжээнд зардал 31.3 сая төгрөгийг санхүүжүүлж байгаа нь Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахаас бусад тохиолдолд хэмнэлтийн горимд шилжиж, тэвчиж болох зардлаас зайлсхийж ажиллаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 6.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолыг зөрчсөн байна.

## 5.4 Зөвлөмж

### 5.4.1 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлант онд тендерийн гэрээний дүнд дүнд өөрчлөлт оруулж нэмэлт гэрээ байгуулсан зөрчил дутагдал илэрлээ

Энэ нь тендерийн жишиг баримт, гэрээний заалтуудтай "Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчаас түүнд төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөлд нийцүүлэн ажлыг гүйцэтгэж, аливаа зөрчил доголдлыг арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны журмыг хэрэгжилтийг ханган ажиллах

#### **5.4.2. Цалин хөлс, урамшуулалтай холбоотой**

Илрүүлэлт: БОЭТ-ийн хангамж соёл үйлчилгээний албаны төрийн үйлчилгээний ажилчдын цалин хөлсийг гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулах замаар цалин хөлсийг нэмэгдүүлээгүй, бусад ажилчдын адилаар хоол, унааны хөнгөлөлтийг олгоогүй, ажлын үр дүнг үнэлж ур чадварын нэмэгдэл сар бүр олгоогүй, ажлын үр дүнгээр улирлын үр дүнгийн нэмэгдлийг олгохгүй байгаа зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022.08.04 өдрийн 1а /3543 албан тоотын 1 дүгээр заалт "үйлчилгээний албан эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулах замаар эмнэлгийн үйлчилгээний ажилтны цалин нэмэгдүүлэх, урамшуулал олгох, байгууллагын дотоод журмын 2.5.1.8-д зааснаар" нийгмийн хамгааллыг бүх ажилтанд ялгаваргүйгээр тэгш хүргэнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022.08.04 өдрийн 1а /3543 албан тоотын хэрэгжилтийг ханган ажиллах.

#### **5.4.3. Цалин хөлс, урамшуулалтай холбоотой**

Илрүүлэлт: БОЭТ-ийн захирлын зөвлөлийн хурлын 2022 оны 12 сарын 12-ны өдрийн 07 дугаар хурлын шийдвэрээр нийт 460 ажилчдаас 216 нэр бүхий албан хаагчид 500.0 - 1900.0 мянган төгрөгийн 197.5 сая төгрөгийн урамшуулал олгож байгаа зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлогыг тухайн үйлчилгээг үзүүлэхэд оролцсон эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, засвар, үйлчилгээ хийхтэй холбоотой гарах зардалд зарцуулна. 4.3 -д "Төлбөртэй төлбөрт үйлчилгээний орлогын зарцуулалтын талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг байгууллагын дарга, захирал нар хангаж ажиллана", байгууллагын Дотоод журмын 2.17.2. -д "Байгууллагын жилийн ажлын үр дүнг ажилтнуудад мэдээлэх", Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, тайлагнах үүргийг эмнэлгийн захирал хүлээнэ. 2.5.1.7. -д "Нийгмийн хамгааллыг бүх ажилтанд ялгаваргүйгээр тэгш хүргэнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан хамтарсан тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах. Урамшууллыг олгохдоо үйлчилгээний орлогыг тухайн үйлчилгээг үзүүлэхэд оролцсон эрүүл мэндийн ажилтан бүрд тэгш олгох, ажил албан тушаалаар ялгаварлан гадуурхахгүй байх.

## **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дотоод журмын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй.	1	10.2	1	10.2	-	-	-	-
Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй.	1	0.5	1	0.5				
Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй.	1	31.2	-	-	1	31.2	-	-
Гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаагүй.	1	45.3					1	45.3
Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022.08.04 өдрийн 1а /3543 албан тоотын хэрэгжилтийг ханган ажиллаагүй.	1	0.0					1	0.0
Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан хамтарсан тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах	1	197.5					1	197.5
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>284.9</b>	<b>2</b>	<b>10.7</b>	<b>1</b>	<b>31.2</b>	<b>3</b>	<b>242.8</b>

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАРАУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:  Д.БАЛЖИННЯМ8417143692  
ПЮ 0073 906



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 08/A2170426

Ховд

ХОА-2022/35/НА/СТА-ТШЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд зардлыг зориулалт бусаар зарцуулсан 531650 төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа боловч төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 531650 /таван зуун гучин нэгэн мянган төгрөг/-ийг захирал П.Гэрэлсүрэнгээс суутган авч Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 04 дүгээр сарын 20-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал П.Гэрэлсүрэн, ерөнхий нягтлан бодогч Д.Баярсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР  
АХЛАХ АУДИТОР  Д.БАЛЖИННЯМ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 04 сарын 15 өдөр

Дугаар \_\_\_\_\_

Ховд

07/A2170426

ХОА-2022/35/НА/СТА-ТШЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд Ач ангаах ухааны Их сургуультай хамтран магистрын сургалт зохион байгуулах гэрээ хийж багш нарын томилолт, унааны зардалд 10262200 төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", байгууллагын дотоод журмын 2.7.8-д "аспирантур, магистр, доктор зэрэг эрдмийн зэрэг цол хамгаалах сургалтын зардлыг байгууллага хариуцахгүй" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 10262200 /арван сая хоёр зуун жаран хоёр мянга хоёр зуун төгрөг/-ийг хавсралтад нэр заасан албан хаагч нараас суутган авч Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 04 дүгээр сарын 20-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал П.Гэрэлсүрэн, ерөнхий нягтлан бодогч Д.Баярсүрэн нэрт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

Д.БАЛЖИННЯМ

**2022-2023 оны магистрын намрын сургалтад элсэгчдийн нэрс**

2023.09.07

№	Овог	Нэр	Регистр	Мэргэжил
1	Пүрэвдаш	Гэрэлсүрэн	ГЖ85011110	Их эмч
2	Батсүх	Одхүү	ПЭ85120917	Халдвар судлаач
3	Бямбадорж	Оюун	ПЮ83091960	Халдвар судлаач
4	Бат-Эрдэнэ	Даваасүх	ПЮ93051755	Их эмч
5	Хүрэлбаатар	Уугантуяа	ПИ90060808	Их эмч
6	Эрдэнэбаатар	Золжаргал	пю91041209	Их эмч
7	Бат-Эрдэнэ	Сүхнаран	ПЭ87050913	Их эмч
8	Эрдэнэчулуун	Өнөржаргал	ПО85120301	Их эмч
9	Лхагважав	Сайнбаяр	ПЗ88072505	Их эмч
10	Цэрэндорж	Сувд-Эрдэнэ	ОЛ88091461	Их эмч
11	Төр-Очир	Энх-Амар	ПЗ96012813	Их эмч
12	Даваа	Цэрэнбадам	пк82013111	Их эмч
13	Баттөмөр	Лхагвасүрэн	пи90041818	Их эмч
14	Баттөмөр	Батбулган	ПА86050115	Их эмч
15	Кабенке	Еркин	пл94012836	Их эмч
16	Намид	Бэрхбол	пв88110315	Их эмч
17	Сүхбаатар	Халиунаа	ПЭ87082700	Их эмч
18	Зэгдээ	Уранцэцэг	ПО84062508	Их эмч
19	Лхамжав	Дэлгэрцэцэг	ПЮ91062201	Их эмч
20	Сандаг	Баттуяа	ПЭ90092824	Их эмч
21	Дуламсүрэн	Чинзориг	ПЗ89061112	Их эмч
22	Батнасан	Мөнхбаатар	ПД88010870	Их эмч
23	Аманбай	Көрихбай	ПК86040412	Их эмч
24	Лхагвацэрэн	Бадамхорлоо	ПЮ74020323	Их эмч
25	Баттөмөр	Уранчимэг	ПЮ77112867	Их эмч
26	Мамай	Сайрангүл	ПЭ86021606	Их эмч
27	Батмөнх	Мөнгөнтөгов	ПН82042908	Их эмч
28	Цагаанцоож	Отгонхишиг	ПЭ89042508	Их эмч
29	Баярхүү	Азжаргал	пв92091701	Их эмч
30	Хахарман	Нуржан	БК87122509	Их эмч
31	Амарсайхан	Оюунгэрэл	ПЮ94041507	Эх баригч
32	Морх	Эрдэнэбаяр	ПЭ78042212	Их эмч
33	Гантөмөр	Батсүх	ПЕ89030332	Их эмч →
34	Цээпил	Золбаяр	ПЭ90032039	Их эмч
35	Ганболд	Шижир	ЧЛ83070272	Их эмч
36	Дэмбэрэл	Мөнхбат	ПЗ84101614	Их эмч
37	Ганхуяг	Энхцэцэг	ПГ89052201	Их эмч
38	Цагаач	Доржханд	пэ78041100	Их эмч
39	Батхүү	Оюунчимэг	ПЮ75120964	Их эмч
40	Бор	Янжинбал	ПГ84122304	Их эмч
41	Чулуунбаатар	Тунгалаг	ПЮ92031869	Их эмч
42	Хүрэлбаатар	Хишигтөгөлдөр	СТ90091616	Их эмч
43	Батхуяг	Дашдаваа	ПА96122013	Их эмч
44	Цэндсүрэн	Цэцэгсүрэн	пю83090164	Эм зүйч

45	Гомбосүрэн	Чинбат	ПП93053119	Сувилагч
46	Мөнхбат	Хишигтогтох	ПЗ93021508	Сувилагч
47	Хишигтогтох	Навчаа	ПЕ74091024	Сувилагч
48	Лувсандорж	Сосорбарам	ПО74122608	Сувилагч
49	Цэвээнсүрэн	Жавзанхорлоо	ПВ97021706	Сувилагч
50	Мягмар	Энхчимэг	ПЮ96100906	Сувилагч
51	Насанжаргал	Төртүвшин	ПО91120416	Сувилагч



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 07/А 2170426

Ховд

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар тайлант онд БОЭТ-ийн захирлын тушаалаар хоолны зардлаас сургалтын хоол, ажилчдын зугаалга, олон нийтийн арга хэмжээнд зардал 31270267 төгрөгийг санхүүжүүлж байгаа нь Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахаас бусад тохиолдолд хэмнэлтийн горимд шилжиж, тэвчиж болох зардлаас зайлсхийж ажиллаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 6.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын баг томилон хяналт хэрэгжүүлж дээр дурдсан зөрчлийг арилган биелэлтийг 2022 оны 04 дугаар сарын 15-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал П.Гэрэлсүрэн, ерөнхий нягтлан бодогч Д.Баярсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

АУДИТОР

Д.БАЛЖИННЯМ

<sup>1</sup> Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагараг баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас:70433061, 70432545